



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ХӨГЖЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
2023 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН
АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: СНАГ-2024/64/НА-СТА-ТШЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Санхүү-Нийцлийн аудитын газрын захирал,
тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг
Утас: 261665 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: Ц.Хосжаргал
Утас:261885 Цахим хаяг: khosjargalts@audit.gov.mn
Аудитор: Б.Ариунжаргал
Утас:267041 Цахим хаяг: ariunjargalb@audit.gov.mn
Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Мишээл-Од Аудит ХХК-ийн
захирал: Т.Одончимэг
Утас: 70169029 Цахим хаяг: info@misheelodaudit.mn

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	2
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.....	10
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	11
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....	11
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	12
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	12
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	13
3.5.1 Төсвийн төлөвлөлт.....	13
3.5.2 Төсвийн гүйцэтгэл	13
3.5.3 Нэмэлт төсөв	13
3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл	14
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	14
4.1 Ерөнхий зүйл	14
4.2 Материаллаг байдал.....	14
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	14
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	15
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	15
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	15
4.5.1 Завсрын аудитын талаар	15
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн.....	15
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	16
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	16
5.1 Албан шаардлага	16
5.2 Зөвлөмж.....	18
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	20

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ЗГ	Засгийн газар
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТБОНӨХБАҮХАТ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ҮАГ	Үндэсний аудитын газар
ХНХ	Хөдөлмөр нийгмийн хамгаалал
ХБХХЕГ	Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ
ХӨГЖЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
Ц.НЯМСҮРЭН ТАНАА

2024.02.23 № 07/360

танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн залруулагдаагүй дараах алдаа, зөрчил нь тогтоосон 33.647.6 мянган төгрөгийн материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна. Үүнд:

- Нийт олгосон 1,552,301.6 мянган төгрөгийн зээлийн авлагаас тайлант онд эргэн төлөлтийн графикийн дагуу төлөгдөх байсан 349,900.0 мянган төгрөг хугацаа хэтэрсэн;
 - Санхүүгийн тайланд бүртгэлтэй 70,643.4 мянган төгрөгийн газар эзэмших эрхийн гэрчилгээг байгууллагын нэр дээр шилжүүлээгүй
- зэрэг зөрчлүүд нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 3 дугаар зүйлийн 3.8 дах заалтуудтай нийцэхгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд төсөв захирагчийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд улсын төсвөөс нийт 1,656,930.5 мянган төгрөгийн санхүүжилт олгосноос төсвийг үндэслэлгүй төлөвлөсөн цалингийн зардал, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл болон нэг удаагийн буцалтгүй тусламжийн зардлаас 529,533.9 мянган төгрөг дутуу зарцуулагдсан байна.

Аудитын гол асуудал

Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар нь Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан "Ability expo 2023" өдөрлөг, арга хэмжээг зохион байгуулсан.

Франц улсын Мэтц хотноо 2023 оны 3 дугаар сарын 24, 25-ны өдрүүдэд зохион байгуулагдсан Олон улсын 10 дахь Абилимп буюу мэргэжлийн ур чадварын уралдаанд Монгол Уулсаас хөгжлийн бэрхшээлтэй 13 оролцогч оролцож, хүрэл медаль хүртсэн.

Мөн 2023 оны 3 дугаар сарын 20-ны өдөр Швейцарын Женев хотноо НҮБ-ын төв байранд зохион байгуулагдсан "Хүний эрхийн зөвлөлийн 52 дугаар хурал"-д Трио киног дэлхийн 190 орны төлөөлөгчдөд үзүүлсэн онцлог үйл явдлуудыг зохион байгуулсан байна.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 21 зорилтын хүрээнд 91 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс гүйцэтгэлээр 82.7 хувийн биелэлттэй гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад асуудлыг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

Хөгжлийн бэршээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын 2023 оны санхүүгийн тайлан төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	1,564,294,371.13	1,574,370,574.13
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	3,900.00	3,900.00
31200	Банканд байгаа бэлэн мөнгө	3,900.00	3,900.00
31210	Төгрөг	3,900.00	3,900.00
31213	Арилжааны банк дахь харилцах	3,900.00	3,900.00
33	АВЛАГА	1,555,655,698.13	1,569,336,298.13
33300	Татаас, санхүүжилтийн авлага	200,000.00	13,980,600.00
33500	Бусад авлага	3,054,098.13	3,054,098.13
33510	Байгууллагаас авах авлага	3,054,098.13	3,054,098.13
33600	Зээлийн авлага	1,552,401,600.00	1,552,301,600.00
33610	Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн авлага	1,552,401,600.00	1,552,301,600.00
33615	Хувийн хэвшлийн аж ахуйн нэгжид олгосон зээл	1,552,401,600.00	1,552,301,600.00
35	БАРАА МАТЕРИАЛ	8,634,773.00	5,030,376.00
35400	Хангамжийн материал	8,634,773.00	5,030,376.00
35410	Бичиг хэргийн материал	4,234,054.00	2,208,080.00
35420	Аж ахуйн материал	217,800.00	217,800.00
35440	Түлш, шатах тослох материал	1,020,423.00	-
35470	Бусад хангамжийн материал	3,162,496.00	2,604,496.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	3,475,311,328.54	3,325,981,764.32
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3,475,311,328.54	3,325,981,764.32
39200	Биет хөрөнгө	3,394,567,176.44	3,255,197,157.49
39201	Барилга, байгууламж, орон сууц	3,500,167,535.00	3,500,167,535.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(397,778,675.03)	(465,731,932.31)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	212,850,000.00	212,850,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(79,149,583.36)	(100,434,583.36)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	237,109,612.00	237,109,612.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(109,737,444.18)	(153,393,293.60)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	39,083,416.88	39,083,416.88
39208	Хуримтлагдсан элэгдэл	(20,600,404.34)	(24,937,778.16)
39214	Бусад үндсэн хөрөнгө	13,387,934.80	13,387,934.80
39215	Хуримтлагдсан элэгдэл	(8,765,215.33)	(10,903,753.76)
39217	Ном	8,000,000.00	8,000,000.00
39300	Биет бус хөрөнгө	80,744,152.10	70,784,606.83
39301	Программ хангамж	17,309,090.91	17,309,090.91
39302	Хуримтлагдсан элэгдэл	(8,654,545.44)	(17,309,090.91)
39303	Бусад биет бус хөрөнгө	77,168,440.00	77,168,440.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	(5,078,833.37)	(6,383,833.17)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	5,039,605,699.67	4,900,352,338.45
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	200,000.00	-
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	200,000.00	-
41300	Өглөг	200,000.00	-
41360	Бусад өглөг	200,000.00	-
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	200,000.00	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	5,039,405,699.67	4,900,352,338.45
51	Засгийн газрын хувь оролцоо	5,039,405,699.67	4,900,352,338.45
51100	Засгийн газрын оруулсан капитал	1,474,849,925.14	1,474,849,925.14
511001	Улсын төсвийн оруулсан хөрөнгө	1,474,849,925.14	1,474,849,925.14
51200	Хуримтлагдсан үр дүн	935,621,694.71	796,568,333.49
51210	Өмнөх үеийн үр дүн	1,095,829,839.62	919,365,128.80
51220	Тайлант үеийн үр дүн	(160,208,144.91)	(122,796,795.31)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,628,934,079.82	2,628,934,079.82
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	5,039,605,699.67	4,900,352,338.45

Хөгжлийн бэршээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын 2023 оны санхүүгийн тайлан төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	4,273,964,899.00	1,697,487,150.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	64,117,199.00	-
120	Нийтлэг татварын бус орлого	64,117,199.00	-
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	11,800,000.00	-
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	11,800,000.00	-
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	52,175,000.00	-
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	142,199.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	4,209,847,700.00	1,697,487,150.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	4,200,997,900.00	1,656,930,460.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	4,200,997,900.00	1,656,930,460.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	8,849,800.00	40,556,690.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	40,319,200.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	8,849,800.00	237,490.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	4,360,121,793.91	1,820,283,945.31
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,360,121,793.91	1,820,283,945.31
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,035,137,621.88	1,243,867,285.86
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	520,369,370.71	704,906,628.48
210101	Үндсэн цалин	342,238,691.99	507,854,662.15
210102	Нэмэгдэл	70,303,791.22	90,129,240.50
210103	Унаа хоолны хөнгөлөлт	75,640,178.08	59,219,464.54
210104	Урамшуулал	31,834,077.27	47,703,261.29
210105	Гэрээт ажлын хөлс	352,632.15	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	66,156,159.02	95,681,714.63
210201	Тэтгэврийн даатгал	47,309,888.86	62,885,981.33
210202	Тэтгэмжийн даатгал	5,517,530.98	11,967,800.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,179,244.70	5,898,408.66
210204	Ажилгүйдлийн даатгал	829,079.88	1,055,324.64
210205	Эрүүл мэндийн даатгал	8,320,414.60	13,874,200.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	49,182,099.72	57,662,502.53
210301	Гэрэл, цахилгаан	21,163,950.35	23,431,805.36
210302	Түлш, халаалт	11,587,625.37	13,247,313.18
210303	Цэвэр, бохир ус	16,430,524.00	20,983,383.99
2104	Хангамж, бараа материалын зардал	35,334,539.39	22,405,121.00
210401	Бичиг хэрэг	5,725,441.00	5,631,574.00
210402	Тээвэр, шатахуун	5,202,808.00	1,020,423.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	8,248,495.39	9,406,451.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	16,157,795.00	6,346,673.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,725,899.00	2,543,500.00
210604	Урсгал засвар	7,725,899.00	2,543,500.00
2107	Томилолт, зочны зардал	6,500,000.00	-
210702	Дотоод албан томилолт	6,500,000.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	207,380,930.00	184,999,655.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	200,521,806.00	180,993,755.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	4,000,000.00	3,000,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	135,924.00	103,900.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,721,000.00	902,000.00

Хөгжлийн бэршээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын 2023 оны санхүүгийн тайлан төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	2,200.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	142,488,624.04	175,668,164.22
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	0.00	26,338,600.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	142,488,624.04	149,329,564.22
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,324,984,172.03	576,416,659.45
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	3,324,984,172.03	576,416,659.45
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,317,523,372.03	576,079,169.45
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	7,460,800.00	237,490.00
213306	Улсын төсвийн орлогод төвлөрүүлэх шилжүүлэг	-	100,000.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	(86,156,894.91)	(122,796,795.31)
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	74,051,250.00	-
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	74,051,250.00	-
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	(160,208,144.91)	(122,796,795.31)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	4,221,847,700.00	1,697,587,150.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	12,000,000.00	100,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	12,000,000.00	100,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	12,000,000.00	100,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	12,000,000.00	100,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	4,209,847,700.00	1,697,487,150.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	4,200,997,900.00	1,656,930,460.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	4,200,997,900.00	1,656,930,460.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	8,849,800.00	40,556,690.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	40,319,200.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	8,849,800.00	237,490.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,221,849,900.00	1,697,587,150.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,221,849,900.00	1,697,587,150.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	896,665,727.97	1,107,189,890.55
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	528,263,827.86	706,087,727.69
210101	Үндсэн цалин	350,133,149.14	506,305,523.86
210102	Нэмэгдэл	70,656,423.37	90,129,240.50
210103	Унаа хоолны хөнгөлөлт	75,640,178.08	59,219,464.54
210104	Урамшуулал	31,834,077.27	50,433,498.79
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	61,315,800.00	110,757,181.33
210201	Тэтгэврийн даатгал	41,724,300.00	62,885,981.33
210202	Тэтгэмжийн даатгал	4,897,900.00	11,967,800.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,918,300.00	9,715,900.00
210204	Ажилгүйдлийн даатгал	979,600.00	2,251,900.00
210205	Эрүүл мэндийн даатгал	9,795,700.00	23,935,600.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	49,182,099.72	57,662,502.53
210301	Гэрэл, цахилгаан	21,163,950.35	23,431,805.36
210302	Түлш, халаалт	11,587,625.37	13,247,313.18
210303	Цэвэр, бохир ус	16,430,524.00	20,983,383.99
2104	Хангамж, бараа материалын зардал	33,869,291.39	20,456,672.00

Хөгжлийн бэршээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын 2023 оны санхүүгийн тайлан төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210401	Бичиг хэрэг	4,682,050.00	3,845,700.00
210402	Тээвэр, шатахуун	5,550,000.00	-
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	8,248,495.39	9,406,451.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	15,388,746.00	7,204,521.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,725,899.00	2,583,700.00
210604	Урсгал засвар	7,725,899.00	2,583,700.00
2107	Томилолт, зочны зардал	6,500,000.00	-
210702	Дотоод албан томилолт	6,500,000.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	209,808,810.00	183,303,507.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	201,638,786.00	179,297,607.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	4,000,000.00	3,000,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	135,924.00	103,900.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,034,100.00	902,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	26,338,600.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	26,338,600.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,325,184,172.03	590,397,259.45
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	3,325,184,172.03	590,397,259.45
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,317,723,372.03	576,079,169.45
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	7,460,800.00	14,218,090.00
213306	Улсын төсвийн орлогод төвлөрүүлэх шилжүүлэг	-	100,000.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	(2,200.00)	-
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	(2,200.00)	-
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	6,100.00	3,900.00
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	3,900.00	3,900.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан
2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,474,849,925.14	2,628,934,079.82	1,095,829,839.62	5,199,613,844.58
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,474,849,925.14	2,628,934,079.82	1,095,829,839.62	5,199,613,844.58
Тайлант үеийн үр дүн			(160,208,144.91)	(160,208,144.91)
2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,474,849,925.14	2,628,934,079.82	935,621,694.71	5,039,405,699.67
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			(16,256,565.91)	(16,256,565.91)
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,474,849,925.14	2,628,934,079.82	919,365,128.80	5,023,149,133.76
Тайлант үеийн үр дүн			(122,796,795.31)	(122,796,795.31)
2023 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	1,474,849,925.14	2,628,934,079.82	796,568,333.49	4,900,352,338.45

Хөгжлийн бэршээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын 2023 оны санхүүгийн тайлан төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,682,382,000.00	1,080,851,290.55	601,530,709.45	64.3
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,682,382,000.00	1,080,851,290.55	601,530,709.45	64.3
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,625,530,000.00	1,080,851,290.55	544,678,709.45	66.5
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,196,781,200.00	706,087,727.69	490,693,472.31	59.0
210101	Үндсэн цалин	516,919,400.00	506,305,523.86	10,613,876.14	98.0
210102	Нэмэгдэл	494,957,500.00	90,129,240.50	404,828,259.50	18.2
210103	Унаа хоолны хөнгөлөлт	96,297,500.00	59,219,464.54	37,078,035.46	61.5
210104	Урамшуулал	88,606,800.00	50,433,498.79	38,173,301.21	56.9
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	149,597,600.00	110,757,181.33	38,840,418.67	74.0
210201	Тэтгэврийн даатгал	101,726,400.00	62,885,981.33	38,840,418.67	61.8
210202	Тэтгэмжийн даатгал	11,967,800.00	11,967,800.00	-	100.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	9,574,200.00	9,715,900.00	(141,700.00)	101.5
210204	Ажилгүйдлийн даатгал	2,393,600.00	2,251,900.00	141,700.00	94.1
210205	Эрүүл мэндийн даатгал	23,935,600.00	23,935,600.00	0.00	100.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	69,721,300.00	57,662,502.53	12,058,797.47	82.7
210301	Гэрэл, цахилгаан	31,128,400.00	23,431,805.36	7,696,594.64	75.3
210302	Түлш, халаалт	18,311,400.00	13,247,313.18	5,064,086.82	72.3
210303	Цэвэр, бохир ус	20,281,500.00	20,983,383.99	(701,883.99)	103.5
2104	Хангамж, бараа материалын зардал	21,607,500.00	20,456,672.00	1,150,828.00	94.7
210401	Бичиг хэрэг	3,911,800.00	3,845,700.00	66,100.00	98.3
210402	Тээвэр, шатахуун	352,300.00	-	352,300.00	-
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	10,030,100.00	9,406,451.00	623,649.00	93.8
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,313,300.00	7,204,521.00	108,779.00	98.5
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,011,700.00	2,583,700.00	1,428,000.00	64.4
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	205,900.00	-	205,900.00	-
210604	Урсгал засвар	3,805,800.00	2,583,700.00	1,222,100.00	67.9
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	183,810,700.00	183,303,507.00	507,193.00	99.7
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	179,304,000.00	179,297,607.00	6,393.00	100.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	3,295,000.00	3,000,000.00	295,000.00	91.1
210803	Даатгалын үйлчилгээ	154,600.00	-	154,600.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	105,300.00	103,900.00	1,400.00	98.7
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	49,800.00	-	49,800.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	902,000.00	902,000.00	-	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	56,852,000.00	-	56,852,000.00	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	56,852,000.00	-	56,852,000.00	-
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	55,381,700.00	-	55,381,700.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,470,300.00	-	1,470,300.00	-
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,682,382,000.00	1,080,851,290.55	601,530,709.45	64.3
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,682,382,000.00	1,080,851,290.55	601,530,709.45	64.3
310001	Улсын төсвөөс санхүүжих	1,682,382,000.00	1,080,851,290.55	601,530,709.45	64.3
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	3,900.00	-	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	3,900.00	-	-
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	35	35	-	100.0
62000	Удирдах ажилтан	1	1	-	100.0
62000	Гүйцэтгэх ажилтан	34	34	-	100.0

Хөгжлийн бэршээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын 2023 оны санхүүгийн тайлан төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан
2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		40,556,690.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ		40,556,690.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		26,338,600.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		26,338,600.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		26,338,600.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		14,218,090.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг		14,218,090.00
213305	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг		14,218,090.00
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		40,556,690.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		40,556,690.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		40,319,200.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		237,490.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын зорилго нь хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх оролцоо, хөгжил хамгааллын талаарх Засгийн газрын бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлж хөгжлийн бэрхшээлтэй хүний нийгмийн харилцаанд оролцох тэгш эрхийг хангах, бие даан хөгжих чадварыг эзэмшүүлэх замаар амьдралын чанарыг нь дээшлүүлэхэд оршино.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар нь хөгжлийн бэрхшээлтэй хүний тэгш эрх болон нийгмийн хамгааллын талаарх төрийн бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийг улсын хэмжээнд зохион байгуулж, биелэлтэд хяналт тавих мөн хөгжих боломжийг нэмэгдүүлэх, хөгжлийн бэрхшээлийн талаар эерэг ойлголт, хандлагыг олон нийтэд төлөвшүүлэх, тэдэнд ээлтэй нийгмийн орчныг бүрдүүлэх, сэтгэл зүй, эрүүл мэндийн хувьд нөхөн сэргээхэд чиглэсэн үйл ажиллагаа явуулж байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус байгууллага үйл ажиллагаандаа Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль, Нийгмийн халамжийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Татварын багц хууль, Боловсролын тухай багц хуулиуд, Гэр бүлийн тухай хууль, Нийгмийн даатгалын ерөнхий хууль, тогтоомжийг мөрдлөг болгож байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Хувь хүний орлогын албан татварын тухай хууль;
- Засгийн газрын 2023 оны 241 дугаар тогтоолоор баталсан Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай;
- Засгийн газрын 2022 оны 448 дугаар тогтоолоор баталсан "Монгол улсын 2023 оны төсвийн тухай хуулийг хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай";
- Сангийн сайдын 2022 оны А/282 дугаар тушаалаар баталсан "Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам" 2023 оноос хэрэгжиж эхэлсэн;
- "Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн хөтөлбөрийг шинэчлэн батлах тухай" Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2022 оны 08 дугаар сарын 26-ний өдрийн А/165 тушаал;
- 2022 оны 06 дугаар сарын 15-ны өдөр Дугаар 33 Тэмдэглэл /Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг нийгмийн харилцаанд саадгүй оролцоход шаардлагатай арга хэмжээг хэрэгжүүлэх талаар тусгасан/;
- Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 21.4, Улсын Их Хурлын 2020 оны 45 дугаар тогтоолын 2, 5 дахь заалтыг тус тус үндэслэн "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ыг шинэчлэн баталсан.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил хэрэгжүүлэхэд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Тус байгууллагын дотоод аудитын чиг үүргийг ХНХЯ-ны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас хэрэгжүүлдэг боловч тайлант жил аудит хийгээгүй тул дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хөгжлийн бэршээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь 2018 онд баталсан байна. Тус бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцээгүй, өөрчлөх шаардлагатай байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Хөгжлийн бэршээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 139,253.4 мянган төгрөгөөр буюу 2.8 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	3.9	3.9	0
Авлага	1,555,655.7	1,569,336.3	13,680.6
Бараа материал	8,634.8	5,030.4	(3,604.4)
Үндсэн хөрөнгө	3,475,311.3	3,325,981.7	(149,329.6)
Нийт хөрөнгө	5,039,605.7	4,900,352.3	(139,253.4)
Өр төлбөр	200.0	0	(200.0)
Засгийн газрын оруулсан капитал	1,474,850.0	1,474,850.0	0
Хуримтлагдсан үр дүн	935,621.7	796,568.3	(139,053.4)
Өмнөх үеийн үр дүн	1,095,839.8	919,365.1	(176,464.7)
Тайлант үеийн үр дүн	(160,208.1)	(122,796.8)	37,411.3
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,628,934.0	2,628,934.0	0
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	5,039,605.7	4,900,352.3	(139,253.4)

Авлага дансны үлдэгдэл 13,680.6 мянган төгрөгөөр өссөн нь 2023 онд НҮБ конвенцын хөрөнгө оруулалтаар зохиогдох байсан төрийн байгууллагын албан хаагчдад дохионы хэлний анхан шатны сургалтыг зохион байгуулах байсан боловч жилийн эцсээр хамрагдах албан хаагчдын ирц бүрдээгүй тул 2024 оны 01 дүгээр сард зохион байгуулахаар төлөвлөж хойшлогдсонтой холбоотой байна.

Авлага дансны үлдэгдэлд Дэл-Оюу Дөл ХХК-тай холбоотой протезын үйлдвэрийг дэмжих зорилгоор 2021 онд олгогдсон 1,552,301.6 мянган төгрөгийн зээлийн авлага бүртгэлтэй байна. Бараа материалын дансны үлдэгдэл 5,030.4 мянган төгрөг болж оны эхнээс 3,604.4 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд албан хэрэг хөтлөлтөд цахим системийг түлхүү ашиглан ажилласантай холбоотой байна.

Бараа материал худалдан авсан 24,997.2 мянган төгрөгөөр нэмэгдэж, зарцуулсан 28,601.6 мянган мянган төгрөгөөр хасагдсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 149,329.6 мянган төгрөгөөр буурсан нь тайлант оны элэгдлийн зардалтай холбоотой байна.

Хөгжлийн бэршээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын 2023 оны санхүүгийн тайлан төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Өр төлбөрийн эхний үлдэгдэлд 2022 оны Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн эргэн төлөлтийн данс андуурагдаж орсон 200.0 мянган төгрөгийн орлогоос үүссэн өглөг бүртгэлтэй байсан ба 2023 онд санд төвлөрүүлснээр үлдэгдэлгүй болсон байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллага 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1,730,217.1 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас зардлыг 1,763,470.8 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, 3,493,687.9 мянган төгрөгөөр баталсан байна. Энэ нь Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа Ховд, Хөвсгөл, Дархан-Уул, Архангай, Дундговь, Дорнод аймгуудад байгуулагдаж байгаа 6 жишиг төвийн санхүүжилтийн зардал юм.

Тодотголоор төсвийг бууруулж, 1,682,382.0 мянган төгрөгөөр тодотгожээ.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,656,930.5 мянган төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Төсвийн нийт зардал 1,080,851.3 мянган төгрөг буюу 64.3 хувийн гүйцэтгэлтэй байгаа нь санхүүжилт 25,451.5 мянган төгрөгөөр дутуу олгогдсон болон үндсэн үйл ажиллагааны зардал төсөвлөснөөс 576,079.2 мянган төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

Төсвийн зарцуулагдаагүй үлдэгдэл 576,979.2 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

Код	Хөтөлбөр, зориулалт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
72206	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжил, хамгаалал	1,682,382.0	1,080,851.3	601,530.7	64.3
80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	1,609,548.0	1,003,217.3	606,330.7	62.3%
80102	Туслах үйл ажиллагааны зардал	51,481.0	51,481.0	-	100%
80219	Бусдаар гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээний зардал	21,353.0	26,153.0	(4,800.0)	122.5%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд төсвийн байгууллагын үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 40,556.7 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ. Үүнээс хичээл, үйлдвэрлэлийн дадлагын зардалд 26,338.6 мянган төгрөг зарцуулж, 14,218.1 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд нийт 250,000.0 мянган төгрөгийн 2 бараа, ажил, үйлчилгээ худалдан авахаар төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр гэрээний дагуу 243,152.9 мянган төгрөгийн санхүүжилтийг гүйцэтгэгч байгууллагад шилжүүлсэн байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой Үндсэн хөрөнгийн ашиглалтын жилийг үнэн зөв тайлагнах, татварын өрийн үлдэгдлийг үнэн зөв тайлагнах, газар эзэмших эрхийн гэрчилгээг гаргуулах зэрэг зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Мишээл-Од Аудит ХХК-ийн газрын ахлах аудитор П.Энхцэлмэг, Д.Дэлгэрмаа, аудитор Х.Гэрэлбаяр, Э.Ундрах-Эрдэнэ, Т.Алтанчимэг, Э.Нямдулам нар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Э.Энхцэцэг, захирал, тэргүүлэх аудитор Т.Одончимэг, Үндэсний аудитын газрын аудитор Б.Ариунжаргал, аудитын менежер Ц.Хосжаргал, Санхүү-Нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар тус тус хэрэгжүүлсэн.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг-Үндэсний Аудитын газарт 2024 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 1/46 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг бага гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны байгууллагын батлагдсан төлөвлөгөөний нийт зарлага 1,682,382.0 мянган төгрөгөөс 2.0 хувиар тооцон 33,647.6 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянахад төсвийн гүйцэтгэл нь батлагдсан төсвөөс материаллаг дүнгээр буурсан тул төсвийн гүйцэтгэлийн нийт зарлага 1,080,851.3 мянган төгрөгөөс 2.0 хувиар тооцон 21,617.0 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоолоо.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага хэмнэх боломжтой зардлуудыг хэмнэх дараах арга хэмжээ авч ажилласан байна. Үүнд:

- Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6.1-т заасны дагуу агентлагийн даргын хэрэглэж байсан суудлын автомашиныг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт шилжүүлсэн
- 21 аймаг 3 дүүргийн түр хамгаалах байр байрны мэргэжилтнүүдийг чадавжуулах сургалтыг НҮБ-ын төслийн санхүүжилтээр зохион байгуулсан

Хөгжлийн бэршээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын 2023 оны санхүүгийн тайлан төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

- Байгууллагын цахилгаан, дулааны зардлыг 22,358.00 мянган төгрөгөөр тус тус хэмнэлт гаргаж ажилласан.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Нийцлийн асуудлаар зөрчил илрээгүй бөгөөд худалдан авах ажиллагаа, шилэн данс зэрэг ажлыг хуулийн дагуу зохион байгуулж ажилласан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 17 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгахад хугацаанд нь байршуулсан байна.

4.5. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар шалгагдагч байгууллагын 2023 оны 3 улирлын санхүүгийн тайланг хамруулж, мөнгөн хөрөнгө, зээлийн эргэн төлөлт, нэмэлт санхүүжилтийн данс, цалин хөлстэй холбоотой дансад горим, сорил хэрэгжүүлсэн.

Жилийн эцсийн аудитаар зөвлөмжийн хэрэгжилтийг хянахад 5 зөвлөмжийг хэрэгжүүлсэн, зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй 116,443.9 мянган төгрөгийн зөрчлийг аудитын тайланд тусгасан болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	6,490.0	1	6,490.0	100.0
Албан шаардлага	2	31,512.8	2	31,512.8	100.0
Зөвлөмж	2	23,922.7	1	14,791.2	50.0
Нийт дүн	5	61,925.5	4	52,794.0	80.0

Өмнөх аудитаар үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй ашиглалтын хугацаа дуусаж, элэгдлээрээ анхны өртөө бүрэн нөхсөн боловч ашиглагдаж байгаа 8 нэр төрлийн 9,131.5 мянган төгрөгийн дансны үнэ бүхий хөрөнгийг бодит үнэ цэнээр нь үнэлж бүртгээгүй, шинэчлэн тогтоох саналыг ТӨБЗГ-т хүргүүлж, шийдвэрлүүлэх зөвлөмжийг хэрэгжүүлээгүй зөрчил давтагдсан тул албан шаардлага хүргүүлээ.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараах асуудлыг дараагийн аудитаар авч үзэх, дээд шатны байгууллага анхаарал хандуулах шаардлагатай байна гэж үзлээ.

- Өмнөх оны аудитаар дурдсан Засгийн газрын 2021 оны 4 дүгээр сарын 07-ны өдрийн 88 дугаар тогтоолоор Дэл-Оюу Дөл ХХК-д протезын үйлдвэрийн үйл ажиллагааг дэмжих зорилгоор 1,552,301.6 мянган төгрөгийн зээлийн авлага бүртгэлтэй ба зээлийн эргэн төлөлт графикийн дагуу тайлант хугацаанд 349,900.0 мянган төгрөгийн зээлийг төлөгдөөгүй;
- Санхүүгийн тайланд бүртгэлтэй 70,643.4 мянган төгрөгийн газрыг тус байгууллага эзэмших эрхээр холбогдох газрын шийдвэр гаргуулах.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 136,174.5 мянган төгрөгийн алдаа илэрснээс аудитын явцад 116,443.9 мянган төгрөгийн 4 алдааг залруулж, 19,730.6 мянган төгрөгийн 2 алдаанд дахин давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө.

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай илэрхийлэгдсэн 4 удаагийн 116,443.9 мянган төгрөгийн алдаанд залруулга хийж, санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

Залруулсан алдаа:

- Үр дүнгийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлангийн Үйл ажиллагааны орлогын дүнг 237.5 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан нь УСНББОУС 1 Санхүүгийн тайлангийн толилуулга стандартын 27-д Санхүүгийн тайланд байгууллагын санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг үнэн зөв толилуулах ёстой гэсэн заалт, санхүүгийн тайлагналын иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангаагүй;
- Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн зардлын санхүүжүүлэх эх үүсвэрийн төлөвлөгөөг 102,052.0 мянган төгрөгөөр дутуу, санхүүжүүлсэн эх үүсвэрийг 207.2 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан нь УСНББОУС 1 Санхүүгийн тайлангийн толилуулга стандартын 27-д Санхүүгийн тайланд байгууллагын санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг үнэн зөв толилуулах ёстой гэсэн заалт, санхүүгийн тайлагналын толилуулга батламж мэдэгдлийг хангаагүй;
- Нэмэлт санхүүжилтийн тайлангийн нийт зардлын дүнг 13,947.2 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан нь УСНББОУС 1 Санхүүгийн тайлангийн толилуулга стандартын 27-д Санхүүгийн тайланд байгууллагын санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг үнэн зөв толилуулах ёстой гэсэн заалт, санхүүгийн тайлагналын толилуулга батламж мэдэгдлийг хангаагүй.

Аудитаар нийт 417,521.7 мянган төгрөгийн зөрчил¹ илэрснээс, 396,400.0 мянган төгрөгийн 4 зөрчилд албан шаардлага хүргүүлж, 21,121.7 мянган төгрөгийн 3 зөвлөмж өгсөн.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 437,252.3 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан тул Хязгаарлалттай дүгнэлт өглөө.

5.1 Албан шаардлага

1. Дэл-Оюу Дөл ХХК-д протезын үйлдвэрийн үйл ажиллагааг дэмжих зорилгоор олгосон 1,552,301.6 мянган төгрөгийн зээлийн авлага бүртгэлтэй ба зээлийн эргэн төлөлтийн графикийн дагуу тайлант хугацаанд 350,000.0 мянган төгрөгийн зээлийн эргэн төлөлт хийгдэхээс 349,900.0 мянган төгрөгийн төлөлтийг хийгээгүй, хугацаа хэтэрсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-т "Энэ хуулийн 5.1.3-т заасан санхүү, төсвийн

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Хөгжлийн бэршээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын 2023 оны санхүүгийн тайлан төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

зохистой удирдлагыг хэрэгжүүлэх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ" 6.4.1.төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйл. "Ерөнхий нягтлан бодогчийн эрх, үүрэг" 20.2.5. "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн: Дэл-Оюу Дөл ХХК-ийн зээлийн эргэн төлөлт хугацаандаа төлөгдөхгүй байгаад арга хэмжээ аваагүй зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэх

2. Элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн нийт 52 нэр төрлийн 106,105.9 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө бүртгэлтэй байгаа ба дахин ашиглагдах боломжтой үндсэн хөрөнгийн үнийг шинэчлэн тогтоогоогүй, өмнөх оны аудитаар өгөгдсөн "Үндсэн хөрөнгөнд тавих хяналтыг сайжруулж, элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн боловч ашиглагдаж байгаа хөрөнгийн үнийг шинэчлэн тогтоох саналыг ТӨБЗГ-т хүргүүлж, шийдвэрлүүлэх" гэсэн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байна. Энэ нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 7.1-д "Төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/106 дугаартай тушаалаар баталсан Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журмын 19.1-д "Шалгагдагч этгээд аудитаар өгсөн зөрчил дутагдлыг арилгах, ...залруулах ажлыг зохион байгуулсан байна."-д 19.2-т "Шалгагдагч этгээд аудитын тайланг баталгаажуулсан тушаалд заасан хугацаанд багтаан албан шаардлага, төлбөрийн акт зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлтийг Төрийн аудитын байгууллагад тайлагнана" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн: Элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн боловч ашиглагдаж байгаа хөрөнгийн үнийг шинэчлэн тогтоох саналыг ТӨБЗГ-т хүргүүлээгүй зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэх.

3. Тайлант онд нийт 1,682,382.0 мянган төгрөгийн санхүүжилт авснаас 576,179.1 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсний 91.8 хувь буюу 490,693.5 мянган төгрөг нь цалингийн зардал, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл болон 56,852.0 мянган төгрөгийн тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн буцалтгүй тэтгэмжийн дутуу зарцуулалт байгаа нь төсвийг үндэслэлгүй төлөвлөсөнтэй холбоотой байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-т "Энэ хуулийн 5.1.3-т заасан санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ: ... 6.4.1.төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах; ..." гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн: Төсвийг үндэслэлтэй төлөвлөөгүйгээс цалин, нийгмийн даатгалын шимтгэл, нэг удаагийн тэтгэмжээс дутуу зарцуулалт бий болсон зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэх.

4. Батлагдсан орон тоонд тусгагдаагүй 3 ажилтныг ажиллуулж 46,500.0 мянган төгрөгийн цалин хөлс олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5-д "Төсвийн шууд захирагч нь төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: ...16.5.3.батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох;..." гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн: Батлагдсан орон тооны хязгаарыг зөрчиж, илүү ажилтныг ажиллуулан цалин хөлс олгосон зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэх.

5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт:

Санхүүгийн программын өөрчлөлтэй холбоотойгоор тайлант жилийн элэгдлийг 3,285.6 мянган төгрөгөөр илүү, 1,601.5 мянган төгрөгөөр дутуу байгуулсан буюу үүнээс 7,491.6 мянган төгрөгийн анхны өртөг бүхий хөрөнгө ашиглалтын хугацаанаас өмнө бүрэн элэгдүүлсэн байна. Энэ нь УСНББОУС -17 Үндсэн хөрөнгө стандартын "66 дахь зүйлд зааснаар хөрөнгийн элэгдүүлэх дүнг түүний ашиглалтын хугацааны туршид системчилсэн сууриар хуваарилна, 67 дахь зүйлд зааснаар хөрөнгийн үлдэх өртөг ба ашиглалтын хугацааг наад зах нь санхүүгийн жил бүрийн эцэст хянаж үзэх", гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

1.2 Өгсөн зөвлөмж:

Үндсэн хөрөнгийн элэгдүүлэх дүнг түүний ашиглалтын хугацааны туршид системчилсэн сууриар хуваарилж, элэгдлийг зөв тооцоолж, санхүүгийн тайланд тусгах.

2. Зардал

2.1 Илрүүлэлт:

Тайлант хугацааны санхүүгийн үр дүнгийн тайланд цалингийн зардлыг 14,843.5 мянган төгрөгөөр илүү тайлагнасан байна. Энэ нь УСНББОУС 1 Санхүүгийн тайлангийн толилуулга стандартын 27-д "Санхүүгийн тайланд байгууллагын санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг үнэн зөв толилуулах ёстой", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2-т "Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ: 20.2.3.холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

2.2 Өгсөн зөвлөмж:

Тайлант хугацааны цалингийн зардлыг цалингийн тооцоололтой нийцүүлж зөв илэрхийлэх

3. Богино хугацаат өр төлбөр

3.1 Илрүүлэлт:

Цалин, хөдөлмөрийн хөлс, тэдгээртэй адилтгах орлогоос суутгасан татварын авлага татварын тооцооллоор 24;175.8 мянган төгрөг, санхүүгийн тайланд 3,054.1 мянган төгрөг буюу 21,121.7 мянган төгрөгөөр авлагыг санхүүгийн тайланд дутуу тайлагнасан байна. Энэ нь УСНББОУС 1 Санхүүгийн тайлангийн толилуулга стандартын 27-д "Санхүүгийн тайланд байгууллагын санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг үнэн зөв толилуулах ёстой", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2-т "Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ: 20.2.3.холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

3.1 Өгсөн зөвлөмж:

Татварын байгууллагатай хийх тооцоог санхүүгийн анхан шатны баримт, тооцоололд үндэслэн зөв тооцож, ХХОАТ-ын ногдуулалт, төлөлтөд тооцоо нийлж, үлдэгдлийг баталгаажуулж байх.

4. Газар эзэмших эрхтэй холбоотой

4.1 Илрүүлэлт:

Санхүүгийн тайланд бүртгэлтэй 70,643.4 мянган төгрөгийн газар эзэмших эрхийн гэрчилгээг тус байгууллагын нэр дээр шилжүүлээгүй байна. Энэ нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 3 дугаар зүйлийн 3.8-д "Газар эзэмших/ашиглах эрх үүсмэгц түүнийг үнэлж, санхүүгийн тайланд бүртгэх саналыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ" гэсэн заалттай нийцэхгүй байна.

4.2 Өгсөн зөвлөмж:

Газар эзэмших эрхийн гэрчилгээг өөрийн байгууллагын нэр дээр шилжүүлэх арга хэмжээ авах

5. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигтэй холбоотой

5.1 Илрүүлэлт:

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь 2018 онд баталсан байна. Тус бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцээгүй, өөрчлөх шаардлагатай байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ 20.2.2.аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулах, батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах; гэсэн заалттай нийцэхгүй байна.

5.2 Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинэчлэгдсэн стандарт, хууль тогтоомжтой нийцүүлэн шинэчлэн баталж, мөрдөж ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2024 оны 9 дүгээр сарын 02-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Үр дүнгийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлангийн Үйл ажиллагааны орлогын дүнг 237.5 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан.	1	237.5	1	237.5			1	237.5				
Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн төлөвлөгөөний зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийн дүнг 102,052.0 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан.	1	102,052.0	1	102,052.0			1	102,052.0				
Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийн дүнг 207.2 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан.	1	207.2	1	207.2			1	207.2				
Нэмэлт санхүүжилтийн тайлангийн нийт зардлын дүнг 13,947.2 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан.	1	13,947.3	1	13,947.3			1	13,947.3				
Санхүүгийн программын өөрчлөлтэй холбоотойгоор тайлант жилийн элэгдлийг 3,285.6 мянган төгрөгөөр илүү, 1,601.5 мянган төгрөгөөр дутуу байгуулсан буюу үүнээс 7,491.6 мянган төгрөгийн анхны өртөг бүхий хөрөнгө ашиглалтын хугацаанаас өмнө бүрэн элэгдүүлсэн байна	1	4,887.1			1	4,887.1			1	4,887.1	1	4,887.1
Тайлант хугацааны санхүүгийн үр дүнгийн тайланд цалингийн зардлыг 14,843.5 мянган төгрөгөөр илүү тайлагнасан байна.	1	14,843.5			1	14,843.5			1	14,843.5	1	14,843.5
Дүн	6	136,174.5	4	116,443.9	2	19,730.6	4	116,443.9	2	19,730.6	2	19,730.6

Хөгжлийн бэршээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын 2023 оны санхүүгийн тайлан төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс										
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн	
Цалин, хөдөлмөрийн хөлс, тэдгээртэй адилтгах орлогоос суутгасан татварын авлага татварын тооцооллоор 24,175.8 мянган төгрөг, санхүүгийн тайланд 3,054.1 мянган төгрөг буюу 21,121.7 мянган төгрөгөөр авлагыг санхүүгийн тайланд дутуу тайлагнасан байна.	1	21,121.7					1	21,121.7					
Дэл-Оюу Дөл ХХК-д протезын үйлдвэрийн үйл ажиллагааг дэмжих зорилгоор олгосон 1,552,301.6 мянган төгрөгийн зээлийн авлага бүртгэлтэй ба зээлийн эргэн төлөлтийн графикийн дагуу тайлант хугацаанд 350,000.0 мянган төгрөгийн зээлийн эргэн төлөлт хийгдэхээс 349,900.0 мянган төгрөгийн төлөлтийг хийгээгүй, хугацаа хэтэрсэн байна.	1	349,900.0			1	349,900.0							
Элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн нийт 52 нэр төрлийн 106,105.9 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө бүртгэлтэй байгаа ба дахин ашиглагдах боломжтой үндсэн хөрөнгийн үнийг шинэчлэн тогтоогоогүй, өмнөх оны аудитаар өгөгдсөн "Үндсэн хөрөнгөнд тавих хяналтыг сайжруулж, элэгдлээрээ анхны өртгөө бүрэн	1				1								

Хөгжлийн бэршээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын 2023 оны санхүүгийн тайлан төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

нөхсөн боловч ашиглагдаж байгаа хөрөнгийн үнийг шинэчлэн тогтоох саналыг ТӨБЗГ-т хүргүүлж, шийдвэрлүүлэх" гэсэн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байна												
Санхүүгийн тайланд бүртгэлтэй 70,643.4 мянган төгрөгийн газар эзэмших эрхийн гэрчилгээг тус байгууллагын нэр дээр шилжүүлээгүй байна.	1					1						
Батлагдсан орон тоонд тусгагдаагүй 3 ажилтныг ажиллуулж 46,500.0 мянган төгрөгийн цалин хөлс олгосон байна.	1	46,500.0			1	46,500.0						
Тайлант онд нийт 1,682,382.0 мянган төгрөгийн санхүүжилт авснаас 576,179.1 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсний 91.8 хувь буюу 490,693.5 мянган төгрөг нь цалингийн зардал, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл болон 56,852.0 мянган төгрөгийн тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн буцалтгүй тэтгэмжийн дутуу зарцуулалт байгаа нь төсвийг үндэслэлгүй төлөвлөсөнтэй холбоотой байна.	1				1							
Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь 2018 онд баталсан байна. Тус бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцээгүй, өөрчлөх шаардлагатай байна	1						1					
Дүн	7	417,521.7	-	-	4	396,400.0	3	21,121.7	-	-	-	-



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 02 дугаар сарын 23

№ 285/А0130055

Улаанбаатар хот

СНАГ-2024/64/ИА-СТА-ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Батлагдсан орон тоонд тусгагдаагүй 3 ажилтныг ажиллуулж, 46,500,000.00 /Дөчин зургаан сая таван зуун мянга/ төгрөгийн цалин хөлс олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5-д "Төсвийн шууд захирагч нь төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: ...16.5.3 батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох;..." гэсэн заалттай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "хууль, тогтоомж, гэрээ хэлцэл зөрчсөн, алдаа зөрчлийг таслан зогсоож давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал үүссэн" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Батлагдсан орон тооны хязгаарыг зөрчиж, илүү ажилтныг ажиллуулан цалин хөлс олгосон зөрчлийг арилгаж, албан шаардлагын биелэлтийг 2024 оны 9 дүгээр сарын 02-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын дарга /Ц.Нямсүрэн/, ерөнхий нягтлан бодогч /Б.Баасандолгор/ нарт даалгав

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
МИШЭЭЛ-ОД АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ
Ц.ХОСЖАРГАЛ
Т.ОДОНЧИМЭГ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 02 дугаар сарын 23 № 286/А0150055

Улаанбаатар хот

СНАГ - 2024/64/НА - СТА - ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд нийт 1,682,382,000.00 /Нэг тэрбум зургаан зуун наян хоёр сая гурван зуун наян хоёр мянга/ төгрөгийн санхүүжилт авснаас 576,179,100.00 /Таван зуун далан зургаан сая нэг зуун далан есөн мянга нэг зуу/ төгрөгийг буцаан төвлөрүүлсний 91.8 хувь буюу 490,693,500.00 /Дөрвөн зуун ерэн мянга зургаан зуун ерэн гурван мянга таван зуу/ төгрөг нь цалингийн зардал, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл, мөн 56,852,000.00 /тавин зургаан найман зуун тавин хоёр мянга/ төгрөгийн тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн буцалтгүй тэтгэмжийн дутуу зарцуулалт байгаа нь төсвийг үндэслэлгүй төлөвлөсөнтэй холбоотой байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-т "Энэ хуулийн 5.1.3-т заасан санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ: ... 6.4.1.төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах; ..." гэсэн заалттай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.1-д "хууль, тогтоомж, гэрээ хэлцэл зөрчсөн, алдаа зөрчлийг таслан зогсоож давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал үүссэн" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төсвийг үндэслэлтэй төлөвлөөгүйгээс цалин, нийгмийн даатгалын шимтгэл, нэг удаагийн тэтгэмжээс дутуу зарцуулалт бий болгосон зөрчлийг арилгаж, биелэлтийг 2024 оны 9 дүгээр сарын 02-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх. хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын дарга /Ц.Нямсүрэн/, ерөнхий нягтлан бодогч /Б.Баасандолгор/ харт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
МИШЭЭЛ-ОД АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ
Ц.ХОСЖАРГАЛ
Т.ОДОНЧИМЭГ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 02 дугаар сарын 23 № 287/А0150055

Улаанбаатар хот

СНАГ-2024/64/НА-СТН-ТЦС

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн нийт 52 нэр төрлийн 106,105,900.00 /Нэг зуун зургаан сая нэг зуун таван мянга есөн зуу/ төгрөгийн үндсэн хөрөнгө бүртгэлтэй байгаа ба дахин ашиглагдах боломжтой үндсэн хөрөнгийн үнийг шинэчлэн тогтоогоогүй, өмнөх оны аудитаар өгөгдсөн "Үндсэн хөрөнгөнд тавих хяналтыг сайжруулж, элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн боловч ашиглагдаж байгаа хөрөнгийн үнийг шинэчлэн тогтоох саналыг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт хүргүүлж, шийдвэрлүүлэх" гэсэн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Энэ нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 7.1-д "Төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2021 оны А/106 дугаартай тушаалаар баталсан Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журмын 19.1-д "Шалгагдагч этгээд аудитаар өгсөн зөрчил дутагдлыг арилгах, ...залруулах ажлыг зохион байгуулсан байна."-д 19.2-т "Шалгагдагч этгээд аудитын тайланг баталгаажуулсан тушаалд заасан хугацаанд багтаан албан шаардлага, төлбөрийн акт зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлтийг Төрийн аудитын байгууллагад тайлагнана" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг давтан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.10-т "аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол;" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн боловч ашиглагдаж байгаа хөрөнгийн үнийг шинэчлэн тогтоох саналыг холбогдох байгууллагад хүргүүлээгүй зөрчлийг арилгаж, албан шаардлагын биелэлтийг 2024 оны 9 дүгээр сарын 02-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын дарга /Ц.Нямсүрэн/, ерөнхий нягтлан бодогч /Б.Баасандолгор/ нарт даалгав.

АЛБАН ШААРДАГА ӨГСӨН:

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
МИШЭЭЛ-ОД АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ
Ц.ХОСЖАРГАЛ
Т.ОДОНЧИМЭГ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

Э. Албан Шаардлага 2024 0223 SN047-01 Docx

00010607-8



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 02 дугаар сарын 23 № 288/А0150055

Улаанбаатар хот

СНАГ-2024/64/НА-СТА-ТЦЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Дэл-Оюу Дөл ХХК-д протезын үйлдвэрийн үйл ажиллагааг дэмжих зорилгоор олгосон 1,552,301,600.00 /Нэг тэрбум таван зуун тавин хоёр сая гурван зуун нэг мянга зургаан зуу/ төгрөгийн зээлийн авлага бүртгэлтэй ба зээлийн эргэн төлөлтийн графикийн дагуу тайлант хугацаанд 350,000,000.00 /Гурван зуун тавин сая/ төгрөгийн зээлийн эргэн төлөлт хийгдэхээс 349,900,000.00 /Гурван зуун дөчин есөн сая есөн зуун мянга/ төгрөгийн төлөлтийг хийгээгүй, хугацаа хэтэрсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-т "Энэ хуулийн 5.1.3-т заасан санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ" 6.4.1.төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйл. "Ерөнхий нягтлан бодогчийн эрх, үүрэг" 20.2.5. "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "хууль, тогтоомж, гэрээ хэлцэл зөрчсөн, алдаа зөрчлийг таслан зогсоож давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал үүссэн" гэж заасныг үндэслэн үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Дэл-Оюу Дөл ХХК-ийн зээлийн эргэн төлөлт хугацаандаа төлөгдөхгүй байгаад арга хэмжээ аваагүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2024 оны 9 дүгээр сарын 02-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын дарга /Ц.Нямсүрэн/, ерөнхий нягтлан бодогч /Б.Баасандолгор/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
МИШЭЭЛ-ОД АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ
Ц.ХОСЖАРГАЛ
Т.ОДОНЧИМЭГ